



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 93

Номгон

Эрдэнэмонгол ХХК-ний үйл ажиллагааг  
дэмжиж, Баянхонгор Нью майнинг орон  
нутгийн өмчит ХХК-ийг хувьцаа  
эзэмшигчээр тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар 16.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 78 дугаар зүйлийн 78.2.3, Эрдэнэмонгол ХХК-ний 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 17/32 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Петер Акерли захиралтай Эрдэнэмонгол ХХК-тай Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ний хамтарсан "Өндөр Гео" нэртэй шинэ хуулийн этгээд байгуулж, хуулийн этгээдийн 20 хувийг Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-д үнэ төлбөргүйгээр шилжүүлэх, цаашид хамтран ажиллахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

2. Орон нутгийн өмчийн оролцооны хувь хэмжээ хариуцсан албан ёсны төлөөлөгчөөр Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ийг томилсугай.

3. Эрдэнэмонгол ХХК, Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ний хооронд байгуулсан гэрээний дагуу шинээр байгуулагдах "Өндөр Гео" компанийн 20 хувийн хувьцаа эзэмшигчээр Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ийг тогтоосугай.

4. Ашиглалтын лиценз авч үйл ажиллагаа явуулах үед Ашигт малтмалын тухай хууль болон гэрээнд заасны дагуу "Өндөр Гео" ХХК-ний 34 хувийг Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-д шилжүүлж байхаар тогтоосугай.

5. "Өндөр Гео" ХХК-д Уул уурхайн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам"-ын 1.6 дахь заалтын дагуу хязгаарлагдмал сонгон

0117233

шалгаруулалтад давуу эрхтэй оролцуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгуулах саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт уламжилсугай.

6. Тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох ажлыг зохион байгуулж ажиллахыг Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Мөнхсайхан/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР